



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/136

Хужирт сум

Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны
өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн "Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай" А/499 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Хөдөө аж ахуйн болон мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулж, биелэлтийн үр дүнг 2023 оны 10 дугаар сарын 15-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ